



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/183

Улаанбаатар хот

┌ Аян зохион байгуулах тухай ┐

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.7.1, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны А/198 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.4, 4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Инээмсэглэх Монгол-Найрсаг Улаанбаатар” нийгмийн аяныг “JCI Монгол” ТББ –тай хамтран хэрэгжүүлж, гэрээ байгуулан ажиллахыг Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн /Б.Халиун/-д үүрэг болгосугай.

2. Аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, шаардагдах төсвийг хавсралт ёсоор баталсугай.


3. Аяныг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал болох 20.000.000 /хорин сая/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын ~~2006~~ оны ~~01~~ сарын ~~31~~-ний
өдрийн ~~11.3~~ тоот тушаалын хавсралт



“Инээмсэглэх Монгол-Найрсаг Улаанбаатар” аяны хүрээнд
зохион байгуулах ажлын төлөвлөгөө, төсөв

№	Үндсэн хөтөлбөр	Үйл ажиллагаа	Шаардагдах төсөв	Хариуцах байгууллага
1	“Байгууллагын найрсаг байдал” соёлын аян	Сургалтын модуль “FISH! Philosophy” – худалдаж авах, орчуулах	6 000 000	JCI Монгол байгууллага
2		Сургагч багш нарыг сонгох, бэлтгэх		JCI Монгол байгууллага
3		Сонгосон төрийн байгууллагуудад сургалт явуулах		JCI Монгол байгууллага, сургалтын төвүүд
4		Аяныг хэрэгжүүлэгч байгууллагуудын удирдах ажилтан, ажлын хэсгийн сургалт зохион байгуулах		JCI Монгол байгууллага, НАЖГ
5		Хөтөлбөр хэрэгжүүлж буй нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон Чингис хаан олон улсын нисэх буудлын харьяа байгууллагуудад аяны хүрээнд тодорхой арга хэмжээнүүдийг санаачлан хэрэгжүүлэх		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд
6	Олон нийтийг хамарсан хөтөлбөр зохион байгуулах	“Та өөрөө гэрэл” богино хэмжээний кино, постерийн уралдааныг явуулах	5 000 000	JCI Монгол байгууллага, Брайт Монголиа байгууллагатай хамт, НАЖГ
7		Дэлхийн инээмсэглэлийн өдрийг угтан “Найрсаг хотын иргэн” олон нийтийн арга хэмжээ	3 000 000	JCI Монгол байгууллага, НАЖГ
8		Олон нийтэд чиглэсэн “Инээмсэглэлийн элч” сорилтот хөтөлбөр зохион байгуулах	1 000 000	JCI Монгол байгууллага

9	Нийслэлийн иргэдийн болон зорилтот бүлгийн "Найрсаг байдлын индекс" тогтоох судалгаа хийх	Нийслэлийн иргэдийн найрсаг байдлын индексийг тооцох аргачлалыг боловсруулах	5 000 000	JCI Монгол байгууллага, MMCG ХХК-тай хамтран
10		Судалгааны асуулга маягыг боловсруулах		
11		Судалгааны маягыг турших		
12		Судалгааны түүвэрлэлтийг боловсруулах, тайлагнах		
Нийт			20 000 000	

Боловсруулсан: НАЖГ-ын Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

Б.Халиун

Танилцсан: Ахлах нягтлан бодогч

П.Ариунаа